



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 2 сарын 13 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Удирдамж батлах тухай

“Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” Засгийн газрын 2020 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн 62 дугаар тогтоолын 4-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацаанд авч хэрэгжүүлэх арга хэмжээний удирдамж”-ийг хавсралтаар баталсугай.
2. Удирдамжид заасан арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг Улсын онцгой комиссын гишүүд, Гамшигаас хамгаалах улсын алба, орон нутгийн Онцгой комиссын дарга, аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагад даалгасугай.

ДАРГА,
ШАДАР САЙД



Ө. ЭНХТҮҮВШИН

Улсын онцгой комиссын даргын 2020
оны 2 дугаар сарын 13-ны өдрийн
04.. дугаар тушаалын хавсралт

ӨНДӨРЖҮҮЛСЭН БЭЛЭН БАЙДЛЫН ЗЭРЭГТ
ХЭСЭГЧИЛСЭН БАЙДЛААР ШИЛЖҮҮЛСЭН ХУГАЦААНД
АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ УДИРДАМЖ

Засгийн газрын 2020 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн 62 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах зорилгоор засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, гамшигаас хамгаалах улс, орон нутгийн алба, хуулийн этгээд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Гамшигаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан Гамшигаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1, 33 дугаар зүйлийн 33.1, 33.3 дахь хэсэгт заасан арга хэмжээг хэрэгжүүлж, гамшигаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийх, шуурхай штаб байгуулах.
2. Гамшигаас хамгаалах улсын болон орон нутгийн албадыг ажлын тусгай горимд шилжүүлэн ажиллах.
3. Шинэ коронавирусийн халдварт бүртгэгдсэн тохиолдолд хорио цээрийн дэглэмийг тогтоох.
4. Гамшигаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн хүч хэрэгслийг томилгоожуулан бэлтгэл бэлэн байдлыг хангах.
5. Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, мэдээ мэдээллийг хэвлэл мэдээллийн бүх хэрэгслээр хүн амд шуурхай, хүртээмжтэй хүргэх.
6. Харилцаа холбоо, хэвлэл мэдээллийн байгууллагууд шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулахтай холбоотой мэдээ, мэдээллийг дараалал харгалзахгүй дамжуулах зохион байгуулалтын арга хэмжээ авах.
7. Цагаан сарын баяртай холбогдолтой бараа бүтээгдэхүүний зар сурталчилгааг хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон бусад хэлбэрээр түгээхийг зогсоох.
8. Хот хоорондын нийтийн тээврийн хэрэгслээр зорчиж байгаа зорчигчдын эрүүл мэндийн байдалд хяналт тавих, тээврийн хэрэгсэлд халдвартгүйтгэл хийх.

9. Гамшгийн нөөцийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах.
10. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг ажлын тусгай горимд шилжүүлэн ажиллуулах.
11. Цагаан сарын баяртай холбогдуулан хүнс, барааны үзэсгэлэн худалдаа зохион байгуулахыг хориглох.
12. Баар, ресторан, нийтийн хоолны болон үзвэр үйлчилгээний газрын ажлын цагийн хуваарыт хязгаарлалт хийх.
13. Олон нийтийг хамарсан уулзалт, сургалт, семинар, ёслол хүндэтгэл, урлаг, спортын арга хэмжээг зогсоох.
14. Шашны байгууллагуудын шашин номын хурал, цуглаан, зан үйлд иргэд, олон нийтийг оролцуулахгүй байх арга хэмжээ авах.
15. Аж ахуйн нэгж, байгууллагыг ажлын тусгай горимд шилжүүлэн ажиллуулах.
16. Бараа, үйлчилгээний үнийн хөөрөгдөл, зохиомол хомсдол үүсгэхгүй байх.
17. Амьсгалын замын цочмог халдварт, томуу, томуу төст өвчинеөр өвчилсөн 5 хүртэлх насны хүүхдээ эмнэлэгт, эсхүл гэрээр асарсан эх, эцэг, асран хамгаалагчид 5 хүртэлх хоногийн цалинтай чөлөө олгох.

Тайлбар: Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг ажлын тусгай горимд шилжүүлэхдээ Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2018 оны А/274 дүгээр тушаалаар баталсан "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг ажлын тусгай горимд шилжүүлэх, ажиллах журам"-ыг баримтална.

-оо-